


# Сурагчийн өөрийн үнэлгээний шалгуурууд

Шинэ Эрин сургуулийн биологийн багш Д. Мөнхтуяа





# Хүснэгтэн мэдээллийн үр дүнд өөрийн үнэлгээ хийх

- ▶ Өөрийгөө үнэлэн доорх оноонуудаас тавина уу.
  - ▶ **2 оноо** – Хэрвээ чи үнэхээр сайн гүйцэтгэсэн бол
  - ▶ **1 оноо** – Хэрвээ чи сайн оролдож, зарим хэсгийг нь амжилттай гүйцэтгэсэн бол
  - ▶ **0 оноо** – Хэрвээ чи хийхээр огт оролдоогүй, эсвэл амжилттай гүйцэтгэж чадаагүй бол
- 




Шалгуур	Оноо
Хүснэгт зурахдаа шугам ашигласан эсэх	
Мөр болон баганы эхний нүд нь тохирох гарчиг болон нэгжийг агуулсан эсэх (харин хүснэгтийн нүднүүдэд ямар нэгэн нэгж бичээгүй байх)	
Чиний хийсэн хүснэгтийг хэн нэгэн хүн хялбархан ойлгож, уншиж чадахуйц болсон эсэх	
Хэрвээ хүснэгт чинь тоон мэдээлэл агуулж байгаа бол бүх нүдэнд байгаа мэдээллийн оронгийн нарийвчлал ижил байгаа эсэх	
Нийт (дээд оноо 8)	


- 
- **8 оноо** Маш сайн
  - **7 оноо** Сайн
  - **5–6 оноо** Сайн болж эхэлж байна, гэхдээ чадвараа бага зэрэг ахиулах шаардлагатай.
  - **3–4 оноо** Сул. Дараагийн даалгавар дээр хүснэгт хийхдээ хүснэгтийн шалгууруудын дагуу хийхийг хичээгээрэй.
  - **1–2 оноо** Маш сул. Бүх шалгууруудыг дахин анхааралтай уншиж үзээд хүснэгтээ дахин хийж үзээрэй.




# Биологийн зураг зурсан үр дүнд өөрийн үнэлгээ хийх

- ▶ Өөрийгөө үнэлэн доорх оноонуудаас тавина уу.
  - ▶ **2 оноо** – Хэрвээ чи үнэхээр сайн гүйцэтгэсэн бол
  - ▶ **1 оноо** – Хэрвээ чи сайн оролдож, зарим хэсгийг нь амжилттай гүйцэтгэсэн бол
  - ▶ **0 оноо** – Хэрвээ чи хийхээр огт оролдоогүй, эсвэл амжилттай гүйцэтгэж чадаагүй бол
- 

Шалгуур	Оноо
Хурц үзүүртэй харандаагаар цэвэрхэн зурж, алдаатай хэсгүүдээ баллуурдаж арилгасан эсэх	
Зөвхөн нэг шулуун зураасаар, давхарлалгүй зурсан эсэх	
Дээжийг зөв хэлбэртэй зурж, ялгаатай хэсгүүдийн харьцааг зөв гаргасан эсэх	
Өгөгдсөн зайг бүрэн ашиглаж, хангалттай том хэмжээтэй зурсан эсэх	
Дээжид харагдаж байгаа бүтцийн ялгаатай хэсгүүдийг бүрэн зурсан эсэх	
Шугамаар нэрлэх шаардлагатай хэсэг хүртэл шулуун татаж, бүрэн нэрлэсэн эсэх	
Нэрийг нь налуу чиглэлд, яг тэр хэсгээ зааж бичсэн эсэх	
Хэрвээ ямар нэгэн сүүдэр юмуу өнгө ашигласан бол нэг оноо хасаарай.	
Нийт (дээд оноо 14)	

- 
- **12 - 14 оноо** Маш сайн
  - **10 - 11 оноо** Сайн
  - **7 - 9 оноо** Сайн болж эхэлж байна, гэхдээ чадвараа бага зэрэг ахиулах шаардлагатай.
  - **5 - 6 оноо** Сул. Дараагийн даалгавар дээр зураг зурахдаа зургийн шалгууруудын дагуу зурахыг хичээгээрэй.
  - **1 – 4 оноо** Маш сул. Бүх шалгууруудыг дахин анхааралтай уншиж үзээд зургаа дахин зурж үзээрэй.




# Туршилтын ажлын төлөвлөлтийн үр дүнд өөрийн үнэлгээ хийх

- ▶ Өөрийгөө үнэлэн доорх оноонуудаас тавина уу.
- ▶ **2 оноо** – Хэрвээ чи үнэхээр сайн гүйцэтгэсэн бол
- ▶ **1 оноо** – Хэрвээ чи сайн оролдож, зарим хэсгийг нь амжилттай гүйцэтгэсэн бол
- ▶ **0 оноо** – Хэрвээ чи хийхээр огт оролдоогүй, эсвэл амжилттай гүйцэтгэж чадаагүй бол





Шалгуур	Оноо
Өөрчилж болох хувьсагчийг тодорхойлж (үл өөрчлөгдөх хувьсагч) түүнийг өөрчилж болох хязгаар болон давтамжийг олж, түүнийг хэрхэн өөрчлөхийг тогтоосон эсэх	
Тогтмол байлгах шаардлагатай хамгийн чухал гурван хувьсагчийг (нэг нь чухал хувьсагч биш байж болно) тодорхойлсон эсэх	
Хэмжилт хийх хувьсагчийг тодорхойлж (хамаарах хувьсагч) хэзээ, хэрхэн яаж хэмжилт хийхээ шийдсэн эсэх	
Үр дүнгийн хүснэгтийг зурсан эсэх	
Таамаглалыг шалгаж байгаа бол “таамаглал зөв” гэж таамаглалын үед гарах үр дүнгийн талаар урьдчилан таамагласан эсэх	
Нийт (дээд оноо 10)	


- 
- **10 оноо** Маш сайн
  - **8 - 9 оноо** Сайн
  - **5–7 оноо** Сайн болж эхэлж байна, гэхдээ чадвараа бага зэрэг ахиулах шаардлагатай.
  - **3–4 оноо** Сул. Дараагийн даалгавар дээр туршилтын ажил төлөвлөхдөө хүснэгтийн шалгууруудын дагуу хийхийг хичээгээрэй.
  - **1–2 оноо** Маш сул. Бүх шалгууруудыг дахин анхааралтай уншиж үзээд туршилтын ажил төлөвлөлтөө дахин хийж үзээрэй.



# Графикийн үр дүнд өөрийн үнэлгээ хийх

- ▶ Өөрийгөө үнэлэн доорх оноонуудаас тавина уу.
- ▶ **2 оноо** – Хэрвээ чи үнэхээр сайн гүйцэтгэсэн бол
- ▶ **1 оноо** – Хэрвээ чи сайн оролдож, зарим хэсгийг нь амжилттай гүйцэтгэсэн бол
- ▶ **0 оноо** – Хэрвээ чи хийхээр огт оролдоогүй, эсвэл амжилттай гүйцэтгэж чадаагүй бол

Шалгуур	Оноо
Өгөгдсөн талбайг бүрэн дүүргэсэн өргөн, өндөртэй тэнхлэгүүдийг шугамаар зурж, тэнхлэгийг нэрлэсэн эсэх	
Х болон У тэнхлэгийг зөв, ижил хэмжээсээр хуваасан эсэх	
Тэнхлэгийн хэмжээсүүдийн нэгжийг зөв тодорхойлсон эсэх	
Өгөгдсөн цэгүүдийг яг зөв, нямбай олсон эсэх	
Олсон цэгээ хэрээс юмуу, гадуураа дугуйтай цэгээр тэмдэглэсэн эсэх	
Тэмдэглэсэн цэгүүдээ дайруулан маш цэвэр, нэг шулуун зураасаар холбосон эсэх	
График байгуулах үедээ алдаатай утгыг хасаж тооцсон эсэх	
Нийт (дээд оноо14)	

- 
- **12 - 14 оноо** Маш сайн
  - **10 - 11 оноо** Сайн
  - **7 - 9 оноо** Сайн болж эхэлж байна, гэхдээ чадвараа бага зэрэг ахиулах шаардлагатай.
  - **5 - 6 оноо** Сул. Дараагийн даалгавар дээр график зурахдаа хүснэгтийн шалгууруудын дагуу хийхийг хичээгээрэй.
  - **1 – 4 оноо** Маш сул. Бүх шалгууруудыг дахин анхааралтай уншиж үзээд графикаа дахин хийж үзээрэй.